

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн  
22/125 тоот тогтоолын Хавсралт 7

**“БОГД БАНК ХК”-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН  
ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**

Баримт бичгийн нэр:	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны ажиллах журам
Хувилбарын дугаар:	1.0
Боловсруулсан нэгж:	ТУЗ-ийн ажлын алба
Хэрэгжилтэд хяналт тавих:	ТУЗ,
Хамаарах нэгж:	ТУЗ, Аудитын хороо

**АГУУЛГА**

1. Нийтлэг зүйл
2. Хорооны бүтэц, бүрэлдэхүүн, томилгоо,
3. Хорооны хурал
4. Хорооны үйл ажиллагааны чиг үүрэг
5. Хорооны үйл ажиллагааны тайлагналт
6. Хорооны болон гишүүдийн ажлыг үнэлгээ
7. Бусад зүйл

Хавсралтууд

## **Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь компанийн засаглалын чиглэлийн дотоод зохицуулалтын баримт бичгийн нэг бөгөөд компанийн бүх албан тушаалтан мөрдөн ажиллах үүрэгтэй.
- 1.3 Энэхүү журмыг компанийн ТУЗ-өөс батлах бөгөөд баталсан өдрөөс эхлэн компанийн хэмжээнд мөрдөгдөнө.
- 1.4 Энэхүү журмыг боловсруулахад засаглалын чиглэлээр ажилладаг Олон улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, Монгол улсын Компанийн тухай хууль, компанийн дүрмийн холбогдох заалт зэргийг үндэс болгосон бөгөөд тэдгээр суурь баримт бичигт өөрчлөлт орох тохиолдолд энэ журамд шаардлагатай өөрчлөлтийг оруулна.
- 1.5 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн ТУЗ-ийн хурлаар тухайн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

## **Хоёр. Хорооны бүтэц, бүрэлдэхүүн, томилгоо**

- 2.1 Хороо нь 3-аас дээш гишүүнтэй байж болох бөгөөд түүний 2/3 нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.2 Хорооны дарга, гишүүдийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос санал болгож, ТУЗ-ийн хурлаар, ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олны саналаар томилж, чөлөөлнө.
- 2.3 Хорооны дарга, гишүүдийг томилохдоо тэдгээрийн мэргэжил, ур чадварыг харгалзан үзэхийн хамт жендерийн тэгш байдлыг хангахад анхаарал тавьсан байна.
- 2.4 Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-өөс хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гаргал хорооны гишүүний ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 2.5 Хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаас гадна мэргэшсэн нягтлан бодогч эсвэл аудитын чиглэлээр мэргэшсэн хүн байна. ТУЗ-ийн дарга нь хорооны дарга байхыг хориглоно.
- 2.6 Аудитын хорооны гишүүд дараах шаардлагыг хангасан байна.
  - 2.6.1 Банкны тайлан тэнцэл, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан зэрэг санхүүгийн суурь тайлангуудыг шинжлэх, дүгнэлт гаргах чадвартай байх;
  - 2.6.2 Компанийн санхүүгийн болон эрсдэл, хяналтын нэгжийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах чадвартай байх;
  - 2.6.3 Банк, санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль зүйн орчин, түүний хүрээнд гарах аливаа өөрчлөлт, түүний банкинд үзүүлж болзошгүй үр дагавар, нөлөөллийг шинжлэх, дүгнэх ажлын мэдлэг туршлагатай байх зэрэг болно. Аудитын хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хуулийн болон бусад чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулж болно.

## **Гурав. Хорооны хурал**

- 3.1 Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хорооны хурал бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байна. Ээлжит хурлыг улиралд нэг удаа хийх ба түүгээр хэлэлцэх асуудлыг тухайн жилийн эхний хурлаар баталж холбогдох албан тушаалтанд хүргүүлэх ба ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд хэдийд ч хуралдаж болно. Хурлыг хуралдуулах шийдвэрийг хорооны дарга гаргах ба дарга тухайн хурлаар хэлэлцэх асуудлыг баталж гишүүдэд хурал болохоос нэг хоногийн өмнө энэ тухайгаа мэдэгдэнэ.

- 3.2 Хорооны хурлыг хуралдуулах саналыг хорооны гишүүд болон компанийн Гүйцэтгэх Удирдлагаас -аас гаргаж болно. Энэхүү саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд хэлэлцэх асуудлын нэр, түүнийг хэлэлцэх шалтгааныг тусгасан байна. Мөн ТУЗ-ийн шийдвэрээр хороо хуралдаж болно.
- 3.3 Хорооны хурлыг хорооны дарга удирдах ба түүний эзгүйд тухайн хурлаас томилсон дарга удирдана.
- 3.4 Хуралд гишүүдийн 2/3 хувь нь оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болох ба хурлаас гарах шийдвэр тухайн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олны саналаар гарна.
- 3.5 Гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд тухайн гишүүн хурлын явцыг сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэрэгслийг ашиглан утсаар эсвэл видео хэлбэрээр оролцож болохоос гадна хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт саналаа бичгээр илгээх замаар оролцож болно. Эдгээр тохиолдолд тухайн гишүүнийг хуралд оролцсонд тооцно.
- 3.6 Хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гадны зөвлөхийг урьж оролцуулж болно.
- 3.7 ТУЗ-ийн ажлын алба нь хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг холбогдох албан тушаалтнаас урьдчилан гаргуулж, гишүүдэд хүргэх ажлыг зохион байгуулахаас гадна хорооны хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж хадгалах ажлыг хариуцна.
- 3.8 Хорооны хурлаас хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд гарах шийдвэр нь ТУЗ болон компанийн Гүйцэтгэх Удирдлага-д зориулсан дүгнэлт, санал, зөвлөмж хэлбэртэй байна.
- 3.9 Хорооны хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шаардлагатай дүгнэлт, саналыг гаргана. Үүнд:
  - 3.9.1 Компанийн Гүйцэтгэх удирдлагаас бэлтгэн ТУЗ-д ирүүлсэн компанийн жилийн тайлангийн өөрийн хариуцдаг ажлын хүрээний асуудал;
  - 3.9.2 Компанийн хэмжээнд дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хэрхэн зохион байгуулагдаж явагдаж байгаа байдал;
  - 3.9.3 Компанийн дотоод аудитын бодлого, дотоод аудиттай холбоотой заавар, журмуудын төсөл, журмуудад орох нэмэлт, өөрчлөлт;
  - 3.9.4 Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн асуудал, аудиторуудын цалин урамшууллын асуудал;
  - 3.9.5 Дотоод аудитын жилийн төлөвлөгөө, түүний биелэлт, Дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэлийн тайлан, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх;
  - 3.9.6 Дотоод аудитын газраас хийсэн аудитын үр дүн;
  - 3.9.7 Дотоод аудитын газрын үйл ажиллагааг дэмжих зорилгоор зөвлөх авч ажиллуулах, чанарын баталгаажуулалттай холбоотой асуудал;
  - 3.9.8 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний төсөл, үйлчилгээний хөлсийг тохирох, хөндлөнгийн аудиттай холбоотой шийдэх асуудал;
  - 3.9.9 Хөндлөнгийн аудитын байгууллагаас баталгаажуулсан банкны тайлан тэнцлийн аудитын тайлангийн үр дүн, тэдгээрийн оруулсан өөрчлөлтийн талаарх асуудал;
  - 3.9.10 Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний гүйцэтгэл;
  - 3.9.11 Монголбанкны хяналт шалгалтын үр дүн;
  - 3.9.12 Монголбанкнаас ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу авсан арга хэмжээний гүйцэтгэл;

- 3.9.13 Монголбанк, Сангийн яам, Татварын газар, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох төрийн байгууллагуудаас банкны санхүүгийн тайлагналт, нягтлан бодох бүртгэлийн зарчимтай холбогдох хууль тогтоомж, заавар журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан банкны үйл ажиллагаанд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үр дагаврын төсөөлөл;
- 3.9.14 Компани дээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл;
- 3.9.15 Өөрийн хорооны үйл ажиллагаа, гишүүдийн ажлыг үнэлсэн дүнгийн тухай;

### **Дөрөв. Хорооны үйл ажиллагааны чиг үүрэг**

4.1 Аудитын хорооны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д компанийн дотоод болон хөндлөнгийн аудит, дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, ёс зүйн дүрэм, хууль журмын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, аудитын үйл ажиллагааны үр дүнг Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д мэдээлэх, банкны удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд байгууллагын сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд орших бөгөөд Аудитын хороо нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### **4.1.1 Дотоод аудиттай холбоотой үүрэг:**

- 4.1.1.1 Дотоод аудитын олон улсын стандарт, шилдэг туршлага, аргачлалыг нэвтрүүлэхэд бүх төрлийн боломжоор хангаж, дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.1.2 Дотоод аудитын газрын удирдлага, аудитуудыг томилж, чөлөөлнө.
- 4.1.1.3 Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, төсвийг баталж, үйл ажиллагааг нь чиглүүлнэ.
- 4.1.1.4 Банкны дотоод аудитын бодлого, дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой заавар, журмыг батлах, аудитын ажлын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, Дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлэлт дүгнэлт өгөх, аудитуудын цалин, шагнал урамшууллын саналыг дүгнэж шийдвэрлэх.
- 4.1.1.5 Аудитын хорооны гишүүд Дотоод аудитын газрын удирдлагатай шаардлагатай үедээ уулзалт хийж, дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
  - 4.1.1.5.1 Гүйцэтгэх удирдлагаас дотоод аудитын ажлыг гүйцэтгэхэд ач холбогдол үзүүлж буй байдал,
  - 4.1.1.5.2 Монголбанкны шалгалтын мөрөөр авах арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлт, тайлагналтын байдал,
  - 4.1.1.5.3 Банкны газар, нэгжийн дотоод хяналтын тогтолцоо, дотоод хяналтын үр дүнтэй байдал,
  - 4.1.1.5.4 Олон улсын дотоод аудитын стандартууд, Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэл, аудитын хууль тогтоомж болон санхүүгийн тайлагналтын зөрүүтэй байдлаас үүсэж буй хязгаарлалтууд байгаа эсэх,
  - 4.1.1.5.5 Дотоод аудитын үйл ажиллагааны чанар, стандартыг бэхжүүлэх хэрэгцээ,
  - 4.1.1.5.6 Дотоод аудитын тайлангуудын дүгнэлт, зөвлөмж, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний хэрэгжилтийн байдал,
  - 4.1.1.5.7 Дотоод аудитын төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн байдал,
  - 4.1.1.5.8 Аудитын хороо болон дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны бусад асуудлууд.

#### **4.1.2 Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой үүрэг:**

- 4.1.2.1 Банкны дотоод хяналтын тогтолцооны зөв зохистой, үр ашигтай байдлыг хэлэлцэх, дотоод хяналтын системийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой заавар, журмын хэрэгжилтэд дүгнэлт гаргах, дотоод хяналтыг боловсронгуй болгох санал дүгнэлтийг банкны удирдлагад зөвлөмж болгох.
  - 4.1.2.2 Санхүүгийн тайланд хийгдэж буй дотоод болон хөндлөнгийн аудитуудын шалгалтын хамрах хүрээ, дотоод хяналтын талаар аудитаар олж илрүүлсэн ноцтой зөрчлийн асуудлууд, зөвлөмжийн талаар банкны Гүйцэтгэх удирдлагатай тусгайлан хэлэлцэж дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлагаас авбал зохих арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.
- 4.1.3 **Хөндлөнгийн аудиттай холбоотой үүрэг:**
- 4.1.3.1 Хөндлөнгийн аудитын хамрах хүрээ, гэрээт ажил үүргийн гүйцэтгэлд хяналт тавих.
  - 4.1.3.2 Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газартай хамтран хөндлөнгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлж, шаардлагатай тохиолдолд аудитын байгууллагыг солих саналыг хэлэлцэж, ТУЗ-өөр батлуулах.
  - 4.1.3.3 Аудитлагдсан санхүүгийн тайлангуудыг хянах, Хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулах бэлтгэл ажлын хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон хөндлөнгийн аудиттай хэлэлцэх.
- 4.1.4 **Хууль, дүрмийн хэрэгжилттэй холбоотой үүрэг:**
- 4.1.4.1 Монгол улсын холбогдох хууль, дүрмийн хүрээнд банкны үйл ажиллагаа нийцэж байгаа эсэхийг хянах.
  - 4.1.4.2 Төрийн холбогдох байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар Гүйцэтгэх удирдлагаас авсан арга хэмжээг хянах.
  - 4.1.4.3 Банкны ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөж буй байдалд дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд банкны холбогдох хороодын хурлын шийдвэр, протоколтой танилцах.
  - 4.1.4.4 Гүйцэтгэх удирдлага болон хуулийн хэлтсээс хууль, эрх зүйн холбогдох баримтын өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх мэдээллийг авах, үүнтэй холбогдуулан банкны холбогдох заавар журамд оруулах өөрчлөлтүүдийн хэрэгжилтийг хянах.

#### **Тав. Хорооны үйл ажиллагааны тайлагнал**

- 5.1 Хороо нь үйл ажиллагаагаа (энэ журмын 4-т заасан чиг үүргэг бүрээр хийсэн ажил, гаргасан дүгнэлт)-ныхаа талаар улирал бүр ТУЗ-д танилцуулж шаардлагатай шийдвэрийг гаргуулж ажиллах;
- 5.2 Хороо нь компанийн дотоод, гадаад аудит, дотоод хяналт, хянан нийцүүлэлт, эрсдэлийн удирдлагын нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, тухайн жилд хийсэн ажлын талаар жил бүрийн төгсгөлд нэгдсэн дүгнэлтийг гаргаж ТУЗ-д танилцуулдаг байх;
- 5.3 Хороо компани дээр тухайн жилд хяналт шалгалт, аудитын талаар хийгдсэн хийгдсэн ажлын ерөнхий тоймыг компанийн жилийн тайланд тусгах ажлыг удирдан зохион байгуулдаг байх;
- 5.4 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд аудитын хорооны үүрэг хариуцлага, ажлын гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийх;

#### **Зургаа. Хорооны болон гишүүдийн ажлыг үнэлгээ**

- 6.1 Хороо өөрийн болон Хорооны дарга, гишүүдийн ажлыг жил бүр энэхүү журмын хавсралт 1-3-т д үзүүлсэн үзүүлэлт аргачлалын дагуу үнэлж дүгнэнэ.
- 6.2 Үнэлэх ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороотой хамтран жил бүрийн 2 дугаар сард Хорооноос зохион байгуулж дүнг ТУЗ-д танилцуулна
- 6.3 Хороо болон түүний гишүүдийн ажлыг үнэлэх ажлыг 360<sup>0</sup>-ийн буюу дараах албан тушаалд ажилладаг ажилтнуудын хүрээнд явуулна. Үүнд:
- 6.3.1 ТУЗ-ийн дарга;
  - 6.3.2 Хорооны дарга, гишүүд;
  - 6.3.3 Компанийн Гүйцэтгэх захирал;
  - 6.3.4 ТУЗ-ийн НБД;
  - 6.3.5 Компанийн дотоод аудит, хяналтын болон хаянан нийцүүлэлтийн нэгжийн удирдлага;
- 6.4 Хороо, түүний дарга, гишүүдийн үнэлгээний ерөнхий дүнг үндэслэн тэдгээрт дараах байдлаар үнэлэлт өгнө.

Тухайн үнэлгээний хүрээнд авсан ерөнхий дүн	Түвшин
Тухайн үнэлэх үзүүлэлтийн хүрээнд авах ёстой үнэлгээний 100-75%	<b>Хэвийн</b>
Тухайн үнэлэх үзүүлэлтийн хүрээнд авах ёстой үнэлгээний 50-75%	<b>Дунд</b> буюу асуудал үүсч болзошгүй
Тухайн үнэлэх үзүүлэлтийн хүрээнд авах ёстой үнэлгээний 25-49%	<b>Хангалтгүй</b> буюу тодорхой арга ажиллагаа явуулах нөхцөл үүссэн
Тухайн үнэлэх үзүүлэлтийн хүрээнд авах ёстой үнэлгээний 25%-иас доош	<b>Муу</b> буюу өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай

## ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба түүний хэрэгжилтэд Аудитын хорооноос ТУЗ-ийн дэргэдэх Ажлын албатай хамтран хяналт тавьж үр дүнг ТУЗ-д мэдээлж байна.
- 7.2 ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба нь энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар жил бүрийн төгсгөлд холбогдох талуудаас санал авч ирсэн саналыг нэгтгэн ТУЗ-д танилцуулан асуудлыг шийдвэрлүүлж байна.

**ХАВСРАЛТУУД:**

1. Аудитын хорооны ажлыг үнэлэх хүснэгт
2. Аудитын хорооны гишүүний ажлыг үнэлэх хүснэгт
3. Аудитын хорооны даргын ажлыг үнэлэх хүснэгт

Богд банк ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын  
хорооны ажиллах журмын Хавсралт 1

**Нэг. Аудитын хорооны ажлыг үнэлэх хүснэгт**

№	Үнэлэх үзүүлэлт	0	1	2	3	4	5	Дүн	Тайлбар
1	Хорооны гишүүдийн мэргэжил, чадвар нь хорооны үндсэн үүрэгтэй хэр нийцэлтэй гэж та үздэг вэ?								
2	ТУЗ-өөс зөв, үр ашигтай шийдвэр гаргахад хороо чухал санал дүгнэлт өгч чаддаг уу?								
3	Хороо үүргээ гүйцэтгэхэд түүний гишүүд шаардлагатай сүүлийн үеийн, арга ажиллагаа, мэдлэг, туршлагыг хэр эзэмшсэн гэж та хэлэх вэ ?								
4	Хороо үндсэн үүргээ хэр биелүүлж чадаж байна гэж үздэг вэ?								
5	Хороо хүнд хэцүү, төвөгтэй асуудал гарахад хэр нухацтай, үр ашигтай ажилладаг вэ?								
6	Хороо өөрийн үүрэгтэй холбоотой компанийн үндсэн бүтцийн нэгжүүдтэй хэр холбоотой ажилладаг гэж та үзэж байна.								
7	Хорооны хуралд гишүүдийн оролцох оролцооны талаарх таны үнэлгээ								
8	Хороо, Гүйцэтгэх удирдлагын хоорондох харилцаанд хэт найрсаг тал гардаг уу								
9	Дүн								

Хорооны ажлыг 0-5 баллаар үнэлэх бөгөөд баллын утга нь дараах байдлыг илэрхийлнэ. Үүнд:  
0 = мэдээлэл байхгүй, 1 = хангалтгүй 2 = сайжруулах шаардлагатай, 3 = байж болох хэмжээнд, 4 = сайн, 5 = бусдад жишээ болох хэмжээнд

**Хоёр. Аудитын хорооны гишүүн ... овогтой ... ний ажлыг үнэлэх хүснэгт**

№	Үнэлэх үзүүлэлт	Үнэлгээ						Дүн	Тайлбар
		0	1	2	3	4	5		
1	Хорооны хуралд оролцох оролцоо								
2	Хорооны хуралд зарчимч байдлаас ханддаг байдал								
3	Хурлаар хэлэлцэж буй асуудлаар чөлөөтэй, урьдаас бодож тунгааж саналаа илэрхийлдэг байдал								
4	Хуралд өөрийгөө бэлтгэж ирдгээс гадна хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт үнэ цэнэтэй нөлөө үзүүлдэг байдал								
5	Өөрийн гаргасан саналаа зөв гэсэн итгэлтэй бол эцсээ хүртэл саналаа хамгаалж чадах байдал								
6	Хангалттай бэлтгэгдээгүй асуудлаар шийдвэр гаргахад татгалзах эсвэл нэмэлт мэдээлэл шаардах чадвар								
7	Бусад гишүүдийн гаргасан саналыг тусган авах, түүний логикийг эргэцүүлэн бодох, санаа авах чадвар								
8	Асуудлыг хурцатгах, үр ашигтай хэлэлцүүлэг үүсгэх хувь хүний зан байдал								
9	Асуудлын мөн чанарыг нарийвчлан тунгаах хурд								
10	Асуудлыг эцэс хүртэл нь хэрэгжүүлэхэд өөрийгөө хөтлөх чадвар								
11	Авч үзэж буй асуудлаар шийдвэр гаргуулахын төлөө чармайдаг байдал								
12	Тавигдаж буй зорилтыг хэрэгжүүлэх арга замын тухай бусад гишүүдэд мэдээлдэг байдал								
13	Шинэ, бүтээлч санаачилга гаргадаг байдал								
14	Асуудалд онолын болон зарчимч байдлаар хандах хандлага								
15	Үүссэн зөрчлийг арилгах чадвар эзэмшсэн байдал								
16	Өөрийн шүүмжлэлийг итгүүлэх чадвар								
17	Бусад гишүүдийн саналыг сонсох, анхаарч авч үзэх чадвар								
18	Зөрчилдөөн үүсэхээс сэргийлж, маргаантай асуудлаар бүтээлч шийдвэр гаргах арга замыг олоход бусад гишүүдэд туслах байдал								
19	Дүн								

Хорооны гишүүдийн ажлыг 0-5 баллаар үнэлэх бөгөөд баллын утга нь дараах байдлыг илэрхийлнэ. Үүнд:

0 = мэдээлэл байхгүй, 1 = хангалтгүй, 2 = сайжруулах шаардлагатай, 3 = байж болох хэмжээнд, 4 = сайн, 5 = бусдад жишээ болох хэмжээнд



**Гурав. Аудитын хорооны даргын ажлыг үнэлэх хүснэгт**

№	Үнэлэх үзүүлэлт	Үнэлгээ						Дүн	Тайлбар
		0	1	2	3	4	5		
1	Хорооны хуралд гишүүдийг санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх бололцоог хангах чадвар								
2	Хорооны ажилд хангалттай цаг зарцуулдаг байдал								
3	Хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг зохих ёсоор санаачлан боловсруулж гишүүдэд мэдээлэх чадвар								
4	Хурлын өмнө гишүүдэд хэлэлцэх асуудлаар өөрийгөө бэлтгэхэд шаардлагатай хугацаа болон мэдээллээр хангадаг байдал								
5	Хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад хурал даргалагчийн давуу талыг гаргадаг байдал								
6	Шинэ гишүүнд ханддаг хандлага								
7	Гишүүдийг хорооны үндсэн үүрэгтэй холбоотой асуудлаар мэдээлэл авахад нь тусалдаг байдал								
8	Хурлуудын хооронд гишүүдтэй ажиллах ажиллагаа								
9	Хорооны үндсэн ажиллагаатай холбогдуулан гишүүдийн хариуцах ажлын чиглэлийг хуваарилан ажиллуулсан байдал								
10	ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврыг үр ашигтай шийдвэрлэх нөхцөлийг ханган ажиллах чадвар								
11	Хорооны дарга гэсэн байдлаар компанийн өдөр тутмын ажилд оролцдог байдал								
12	Хорооны ажлыг үнэлэх ажиллагааг зохион байгуулдаг байдал								
13	Хорооны ажлыг удирдан зохион байгуулж байгаа байдал								
14	Компанийн Гүйцэтгэх удирдлагатай хэт нөхөрсөг харьцаатай эсэх								
15	Дүн								

Хорооны даргын ажлыг 0-5 баллаар үнэлэх бөгөөд баллудад утга нь дараах байдлыг илэрхийлнэ.  
Үүнд:

0 = мэдээлэл байхгүй, 1 = хангалтгүй, 2 = сайжруулах шаардлагатай, 3 = байж болох хэмжээнд, 4 = сайн, 5 = бусдад жишээ болох хэмжээнд